



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 11/154

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх сунгах
хүчингүй болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 14 дүгээр зүйлийн 14.1.4, 16 дугаар зүйлийн 16.2.5, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын "Амармандал", "Өргөн ундраа", Эрдэнэдалай сумын "Содбилэгдалай" ХХКомпаний хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, Адаацаг сумын "Санжаасүрэн" ХХКомпаний "караоке pub"-ын спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар тус тус сунгасугай.


Хоёр. Сайхан-Овоо сумын "Онгийн нууц", "Цогтын шар мөрөн" Сайнцагаан сумын "Алтанцант" ХХК-ны "Бага газрын чулуу" жуулчны баазуудын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаагаар сунгасугай.

Гурав. Сайнцагаан сумын "Ээдмор" ХХК-ний хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

Дөрөв. Эрдэнэдалай сумын "Содбилэгдалай" Сайнцагаан сумын "Амармандал" ХХК-ний "Нарлаг", хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 09.00-21.00, "Өргөн Ундраа", "Төгрөг мандал", "Эхэн хөшөөт" ХХК-ний хүнсний дэлгүүрийн ажиллах цагийн хуваарийг 08.00-23.00, Адаацаг сумын "Санжаасүрэн" ХХК-ний "караоке pub"-ын ажиллах цагийн хуваарийг 09.00-24.00 цаг хүртэл тус тус баталсугай.

Тав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах, хүчингүй болгох шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Татварын хэлтэс /М.Туяацэцэг/, Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/, Сайнцагаан, Адаацаг, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

003000466